



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020

Э-сонин

78-р дугаар

1-Р САР






ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн тойм


/2020.01.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	22
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	4,230,925,311
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	4,230,925,311
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	14,748,536
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	14,748,536
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	3,921


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	170
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	57
Үүнээс: Брокер, Дилер	51
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.01.31-ний байдлаар/

№	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард секюритиз ХХК	4,687,917	3,188,071,935	4,675,591	3,180,679,052	6,368,750,987
2	Мирэ Эссет Секьюритис Монгол	5,990,761	277,801,446	6,052,013	290,597,141	568,398,587
3	БиДиСек ХК	1,061,128	119,421,012	178,823	102,091,597	221,512,609
4	Голомт Капитал ХХК	488,843	69,029,774	777,154	141,793,892	210,823,666
5	Ги Ди Би Капитал ХХК	287,241	82,132,491	587,287	89,241,772	171,374,263
6	Стандарт инвестмент ХХК	382,535	74,681,978	787,282	66,810,121	141,492,099
7	Бумбат-Алтай ХХК	254,583	86,797,949	186,480	43,464,178	130,262,127
8	Ард капитал групп ХХК	588,983	88,612,237	211,311	23,531,284	112,143,521
9	Тулгат чандмань баян ХХК	38,285	27,951,950	45,468	38,821,489	66,773,440
10	Инвескор капитал ҮЦК	1,191	3,156,144	23,203	59,320,310	62,476,454
11	Новел инвестмент ХХК	44,680	27,604,293	148,482	18,844,676	46,448,969
12	Гаүли ХХК	47,428	11,625,065	447,115	31,857,061	43,482,126
13	Апекс Капитал ҮЦК	187,747	20,767,795	125,848	15,964,348	36,732,143
14	Сикап ХХК	450,173	31,452,481	345	72,968	31,525,449
15	Дэлгэрхангай секюритиз ХХК	2,158	15,284,695	3,392	15,243,960	30,528,655
16	Блүмсбюри секюритиес ХХК	6,425	16,546,370	142,590	11,883,250	28,429,620
17	Зэргэд ХХК	17,300	13,154,686	37,964	8,267,128	21,421,814
18	Монгол секюритиес ХК	33,434	20,662,913	0	0	20,662,913
19	Монсек ХХК	41,417	8,086,114	30,549	6,751,302	14,837,415
20	Батс ХХК	0	0	7,670	13,773,082	13,773,082

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.01.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	3,619,028	2,272,946,474	699	600	-11.97
2	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	528,961	886,196,698	1,775	1,500	-10.65
3	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	6,707,659	305,990,023	44.9	40.1	0.66
4	INV	ИНВЕСКОР ББСБ	40,749	105,851,174	2,999	2,195	20.84
5	APU	АПУ	142,280	87,668,461	635	600	-3.04
6	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,435,218	72,113,450	52	49	-1.03
7	GOV	ГОВЬ	255,552	68,555,348	294	252	-4.16
8	TUM	ТҮМЭН ШУВУУТ	441,713	67,541,622	164	137	-3.61
9	TTL	ТАВАН ТОЛГОЙ	10,229	66,605,710	6,600	6,450	-0.15
10	MFC	МОНОС ХҮНС	571,576	39,911,874	72	68.3	2.42
11	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	474,709	36,896,001	80	75	-4.36
12	BDS	БИ ДИ СЕК	37,563	31,932,254	852	850	0.24
13	AIC	АРД ДААТГАЛ ХК	41,553	30,324,457	798	702	-8.74
14	MMX	МАХИМПЕКС	9,315	22,285,802	2,590	2,215	-3.52
15	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18,220	20,829,524	1,299	915	2.61
16	MBW	МОНГОЛ БАЗАЛТ ХК	65,186	16,827,187	265	250	1.48
17	GTL	ГУТАЛ	962	14,672,000	16,000	15,250	-4.69
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	792	11,886,810	15,990	14,500	3.81
19	SUU	СҮҮ	55,041	11,396,949	213	201	-1.10
20	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	100	9,374,240	100,000	90,080	-7.89



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2019-12-31	2020-01-31		
1	МОНГОЛ ДААТГАЛ	258	70.00	214.08	144.08	205.83
2	ИНВЕСКОР ББСБ	40,749	2,198.00	2,656.00	458.00	20.84
3	МОГОЙН ГОЛ	65	7,655.00	8,855.00	1,200.00	15.68
4	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,602	338.44	389.85	51.41	15.19
5	СОР	189	1,000.00	1,150.00	150.00	15.00
6	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	71	4,243.00	4,879.00	636.00	14.99
7	ХИШИГ УУЛ	30	523.88	602.00	78.12	14.91
8	ТАВ	8	17,500.00	20,100.00	2,600.00	14.86
9	АВТО ИМПЕКС	10	2,005.00	2,300.00	295.00	14.71
10	АДУУН ЧУЛУУН	1,200	1,180.00	1,350.00	170.00	14.41
11	ХАСУ-МАНДАЛ	31	7,460.00	8,520.00	1,060.00	14.21
12	ТАХЬ-КО	45	13,100.00	14,790.00	1,690.00	12.90
13	БАГАНУУР	329	949.76	1,045.00	95.24	10.03
14	БАЯНТЭЭГ	39	25,000.00	27,500.00	2,500.00	10.00
15	ГЕРМЕС ЦЕНТР	29,255	132.98	145.98	13.00	9.78
16	МОНИНЖБАР	10	101.00	110.00	9.00	8.91
17	ОЛЛОО	1	63.00	66.00	3.00	4.76
18	УВС ЧАЦАРГАНА	466	315.00	330.00	15.00	4.76
19	ГАН ХИЙЦ	15	12,000.00	12,500.00	500.00	4.17
20	ТАЛХ ЧИХЭР	792	15,220.00	15,800.00	580.00	3.81

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт /%/
			2019-12-31	2019-01-31		
1	УБ-БҮК	7,334	458.00	300.00	-158.00	-34.50
2	СИЛИКАТ	5,231	68.00	50.00	-18.00	-26.47
3	ХАР ТАРВАГАТАЙ	30	6,640.00	5,000.00	-1,640.00	-24.70
4	ИХ БАРИЛГА	20	3,200.00	2,700.00	-500.00	-15.63
5	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	3	340.00	290.00	-50.00	-14.71
6	ХАНЫН МАТЕРИАЛ	1	2,200.00	1,880.00	-320.00	-14.55
7	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	500	90.00	77.00	-13.00	-14.44
8	ДАРХАН НЭХИЙ	19	13,980.00	12,010.00	-1,970.00	-14.09
9	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	33	750.00	650.00	-100.00	-13.33
10	ХЭРЛЭН ХИВС	2	45.00	39.00	-6.00	-13.33
11	МОНГОЛ ШУУДАН ХК	3,619,028	725.00	638.20	-86.80	-11.97
12	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	7,347	698.43	621.00	-77.43	-11.09
13	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	528,961	1,766.00	1,578.00	-188.00	-10.65
14	ТЭЭВЭР ДАРХАН	184	8,625.00	7,800.00	-825.00	-9.57
15	МЕРЕКС	3,674	22.02	19.99	-2.03	-9.22



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОГЧ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОХ ТОП-20 ИНДЕКСИЙН САГСЫГ ШИНЭЧИЛЛЭЭ

Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай" журмын дагуу үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн сагсыг жилд 1 удаа шинэчлэн тооцоолдог билээ. Уг журмын дагуу ТОП-20 индексийн сагс шинэчлэгдэж, 2020 онд ТОП-20 индексийн сагсыг дараах үнэт цааснууд бүрдүүлэхээр боллоо.

2019 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 13 компани хэвээр үлдэж, "Гутал" ХК, "Айтүүлс" ХК, "Хай Би Ойл" ХК, "Женко тур бюро" ХК, "Махимпекс" ХК, "Дархан нэхий" ХК, "Талх чихэр" ХК-иуд хасагдаж, шинээр "Ард кредит ББСБ" ХК, "Инвескор ББСБ" ХК, "Монос хүнс" ХК, "Түмэн шувуут" ХК, "Шарын гол" ХК, "Улсын их дэлгүүр" ХК, "Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн" ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

"БАЯН АЛДАР ББСБ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООЛОО

"Баян Алдар ББСБ" ХК-ийн 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн нэгж хувьцааг 50 хуваахаар шийдвэрлэж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн бөгөөд СЗХ-ны 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн тул Хорооны улсын байцаагчийн 2020 оны 01 сарын 16-ны өдрийн 22 тоот албан шаардлагын дагуу "Баян Алдар ББСБ" ХК-ийн үнэт цаасны арилжааг 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн түр зогсоохоор боллоо.

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-ИАС МЭДЭГДЭЛ ИРҮҮЛЛЭЭ

"Ард Кредит ББСБ" ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн бөгөөд 2018 онд Санхүүгийн зохицуулах хорооноос цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан болно. Харин Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэн үндэсний төлбөрийн системтэй холбоотой бүх асуудалд Монголбанк хяналт тавихаар болсны дагуу Монголбанкнаас уг асуудлаар тодруулга хүсэхэд цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах шаардлагатай гэсэн хариу өгсөн. Үүний дагуу 2019 оны 9 сард Монголбанкинд цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтээ гаргасан болно.

Уг тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, баримт бичгийг Монголбанкнаас хянаж үзэн нэмэлт материал ирүүлэхийг хүссэн бөгөөд шаардлагатай материалуудыг хүргүүлэхээр "Ард Кредит ББСБ" ХК ажиллаж байна.



"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ КОМПАНИАС ШААРДАХ ЭРХ ҮҮСЭВ

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Хорго Хайрхан" ХК нь 2019 оны 4 сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа компанид "Монгол даатгал" ХХК-ийг нэгтгэхээр шийдвэрлэсэн бөгөөд энэхүү нэгдэлтэй холбоотой асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 372 тоот тогтоолоор зөвшөөрсөн болно.

Үүнтэй холбогдуулан дээрх шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн огноо: **2019 оны 12-р сарын 16-ны өдөр**

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: **2020 оны 1-р сарын 31-ний өдрийг хүртэл**

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: **652.37 төгрөг**

Шаардах эрх хэрэгжүүлэгч "Монгол даатгал" ХК: УБ, СБД, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, "Монгол даатгал" ХК-ийн байр, холбогдох утас: 11-313697, 99036048, 88424455, 99059828

"Говь" ХК нь 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6.8 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компани дээрээ олгож байсан бол ҮЦТХТ-тэй 2019 оны 12 сарын 25-ны өдөр байгуулсан гэрээний дагуу 2018 оны ногдол ашгийн үлдэгдэл болох 16,473 хувьцаа эзэмшигчдийн 76,352,838 ширхэг хувьцаанд ногдох 466,852,056.56 төгрөгийг /ХАОАТ суутгасан дүн/ хувьцаа эзэмшигчдийн дансанд 2019 оны 12 сарын 31-ний өдөр байршуулсан байна.

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИАС МЭДЭГДЭЛ ИРҮҮЛЛЭЭ

"ЛэндМН ББСБ ХК" нь "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хууль болон тус хуульд нийцүүлэн гаргасан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 5 сарын 23-ны өдрийн 193 тоот тогтоолоор олгогдсон "Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх", "Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах" тусгай зөвшөөрлийн дагуу "Лэнд Хэтэвч" үйлчилгээг үзүүлж байна. Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хорооны албан ёсны цахим хуудас дахь дараах холбоосоор танилцах боломжтой.

"ЛэндМН ББСБ" ХК нь хууль тогтоомжийн зарим зөрчилтэй, ойлголтын зөрүүтэй байдлыг тодруулахаар Монголбанкинд хандсан ба уг асуудлууд тодорхой болмогц Монголбанкинд тусгай зөвшөөрлийн хүсэлтийг дахин хүргүүлэхээр ажиллаж байна.



ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ЭЦСИЙН ТЭЗҮ БОЛОН АНХАН ШАТНЫ ИНЖЕНЕРИЙН ЗАГВАРЧЛАЛЫН АЖЛУУДЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

2019 оны 12 сараас Эрдэнэ Ресурс нь тусгай зөвшөөрлүүд авах, төслийн санхүүжилт болон уурхайн дэд бүтцийг барих ТУЗ-ийн шийдвэр гаргахад шаардлагатай судалгаанууд болох эцсийн ТЭЗҮ("BFS"), анхан шатны инженерийн загварчлал ("FEED")-ын судалгаануудыг боловсруулж эхлээд байна. Эцсийн ТЭЗҮ нь National Instrument 43-101 эрсдлийн төслийн тайлагналын стандартын дагуу боловсруулагдах бөгөөд ТЭЗҮ-д уурхайн загварчлал, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны инженерийн загварчлал, гидрогеологийн судалгаа, хаягдлын удирдлагын нарийвчилсан төлөвлөгөө болон эдийн засгийн загварчлал зэрэг багтах бөгөөд 2020 оны дундуур танилцуулахаар төлөвлөж байна.

"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ СЭРГЭЭХЭЭР БОЛЛОО

"Монгол даатгал" ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 21 тоот албан шаардлага нь Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаа эхэлснээс хойш ирсэн тул "Монгол даатгал" ХК-ийн хувьцааны арилжааг 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр нээхээр боллоо.

Тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан үнэт цаасны арилжааг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түр зогсоогоод байсан билээ.

Үйл явдал

"ИНВЕСКОР ББСБ" ХК НЬ КИРГИЗИЙН КОМПАНИД ХӨРӨНГӨ ОРУУЛЛАА

"Инвескор ББСБ" ХК нь Бүгд Найрамдах Киргиз улсын Золотой стандарт санхүүгийн компанид хөрөнгө оруулж гаргасан нийт хувьцааг худалдаж авч байгаа бөгөөд 2020 ондоо багтаан финтек технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг тус улсад нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Киргизийн "Золотой стандарт" ХХК нь 2004 онд байгуулагдсан, бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, Бишкек хотод 1 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд бага дүнтэй жижиг дунд бизнесийн санхүүжилт, хэрэглээний барьцаат зээлийг голлон олгодог компани юм.

"Инвескор ББСБ" нь санхүү, финтек болон хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ба компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу Төв Азийн зах зээлд нэвтрэхээр ажиллаж байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN